



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

Танилцуулга хянасан:

Хэлтсийн дарга Г.Чинжаргал

Танилцуулга бэлтгэсэн:

Ахлах мэргэжилтэн Н.Дэлгэрмаа

Холбоо барих:

Баянгол дүүрэг 4-р хороо
Засаг даргын тамгын газрын байр
114 тоот
Веб: www.nso.mn, www.bgd.mn
Утас: 70122688, 301637
И-мэйл: bayangol@nso.mn



МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, УРСГАЛ

Манай улсын хувьд ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэдийн статистикийн мэдээллийг цуглуулах ажлыг тодорхой үе шаттайгаар шинэчлэн боловсруулж ирснийг дор харууллаа.

1997

1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 71 тоот тушаалаар батлагдсан Ажилгүйчүүдийн сарын мэдээний /Маягт АХ-3/

2011

2011 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/67 тоот тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн /Х33-1, Х33-2, Х33-3 маягт/

2011

2011 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн Үндэсний Статистикийн хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан /Маягт Х33-4а, Х33-4б, Х33-5, Х33-6а, Х33-6б, Х337а, Х33-7б, Х33-7в/

2014


2014 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс Ажил хайгч иргэний хөдөлгөөний /Маягт Х33-6/, Ажил хайгч иргэний/Маягт Х33-7а,7б/, Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний/Маягт Х33-6/, Бүртгэлтэй ажилгүй иргэний /Маягт Х33-7а, 7б/, Ажлын шинэ байранд орсон иргэний сарын мэдээ /Маягт Х33 5а,5б,5в/

Энэхүү мэдээллийг батлагдсан маягт, зааврын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сар бүр хүлээн авч, нягтлан шалгаж, бүртгэлтэй ажилгүй иргэд, шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, бүртгэлтэй ажилгүй иргэдээс ажилд орсон хүн зэрэг үзүүлэлтүүдийг сар, жилийн бюллетень, танилцуулга болон www.ubstat.mn сайтад байршуулан нийтэд тархааж байна.

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны эцэст 2160, үүнээс 1153 (53.4%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 1007 (46.6%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Зураг 1. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, төрөл



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил хайж бүртгүүлсэн иргэдийг насны бүлгээр авч 909 нь (42.1%) 15-24 насны, 596 нь (27.6 %) 25-34 насны, 386 нь (17.9%) 35-44 насны, 200 нь (9.3%) 45-54 насны, 57 нь (2.6%) 55-59 насны, 12 нь (0.5%) 60-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 1. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, насны бүлэг, хүйсээр, оны эцэст

Дүүрэг		2015	2016	2017	2018	2019
Бүгд		3110	2248	1319	1153	2160
	эмэгтэй	1668	1219	752	663	1169
15-24		622	246	366	199	909
	эмэгтэй	316	125	191	117	472
25-34		1187	913	499	449	596
	эмэгтэй	648	515	300	265	333
35-44		745	622	241	290	386
	эмэгтэй	427	346	149	177	209
45-54		428	362	136	148	200
	эмэгтэй	227	195	77	79	126
55-59		98	81	56	52	57
	эмэгтэй	38	27	27	21	22
60+		30	24	21	15	12
	эмэгтэй	12	11	8	4	7

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажил хайгч иргэдийн 0.9 хувийг магистр, доктор, 24.2 хувийг дипломын болон бакалаврын, 2.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.4 хувийг техникийн болон мэргэжлийн, 65.4 хувийг бүрэн дунд, 5.6 хувийг суурь, бага боловсролтой болон боловсролгүй иргэд эзэлж байна.

Бүрэн дунд боловсролтой ажил хайгч иргэд 2015 онд 55.6 хувийг эзэлж байсан бол, 2016 онд 41.5 хувийг, 2017 онд 42.9 хувийг, 2018 онд 46.6 хувийг, 2019 онд 65.4 хувь болж өсөн нийт ажил хайж бүртгүүлсэн иргэдийн талаас илүү хувийг эзэлж байна.

Зураг 2. Ажил хайж бүртгүүлсэн иргэд, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар, 2019 оны эцэст



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН СТАТИСТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ажиллах хүчний судалгааны 2019 оны дүнгээр Баянгол дүүргийн хэмжээнд 4016 ажилгүй иргэд байна. Эдгээрээс хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэд 2019 оны эцэст 1153 болсны 605 нь эмэгтэйчүүд байна.


Хүснэгт 2. Бүртгэлтэй ажилгүй иргэд, хөдөлгөөнөөр

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Бүртгэлтэй ажилгүй иргэд	1 807	1 532	921	822	1 153
Шинээр бүртгүүлсэн иргэд	5 911	6 007	3 178	3 409	5 173
Ажилд зуучлагдан орсон иргэд	1 145	990	1 219	1187	1 544
Ажил хайхгүй шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд	5 448	5 589	2 570	2 338	3 298

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2019 онд жилд давхардсан тоогоор ажилгүй 5 173 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 1 544 иргэн ажилд зуучлагдан орж, 3 298 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь өмнөх оныхтой харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 51.7 хувиар, ажилд зуучлагдан орсон иргэд 30.1 хувиар, ажил хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 41.1 хувиар тус тус өссөн.

Зураг 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлэг, дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

2019 оны байдлаар нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.7 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 4. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, ажил хайж байгаа шалтгаанаар, 2019 оны эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2019 оны эцэст 351 хүн шинээр бүртгүүлсний 77.5 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна. Бүртгэлтгүй ажилгүй иргэдээс 2019 оны эцэст 190 хүн ажилд зуучлагдан орсны 177 (93.2%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 6 (3.2%) нь төсөвт байгууллагад, 5 (2.6%) нь төрийн өмчит үйлдвэрийн газарт, 1 (0.5%) нь хувьцаат компанид, 1 (0.5%) нь бусад байгууллагад орсон байна. Ажилд зуучлагдан орсон иргэдийн 74.2 хувийг 15-34 насны иргэд эзэлж байгаа бол 70.5 хувь бүрэн дунд боловсролтой байна.


Зураг 5. Ажилд зуучлагдан орсон хүн, насны бүлэг, боловсролын түвшнээр, 2019 оны эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Баянгол дүүргийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 14 (1.2%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 6 (42.9%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 6. Хөгжлийн бэрхшээлтэй бүртгэлтэй ажилгүй иргэд, хүйсээр



Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам